

## Mongolian

"Эдгээр хүмүүсийн царайны илрэл нь хэн нэгэнд хир их өвдөлттэй байж болохыг харуулж байна. Хамгийн зүүн талд байрлаж байгаа хүний царай бол ерөөсөө өвдөхгүй байгаа хүнийг харуулж байна. Зүүнээс баруун тийшлэх тутам /дараа дараагийн хүмүүсийн царайны илрэл нь улам их өвдөлттэй болж байгааг заана. Хамгийн баруун талд байрлаж байгаа хүний царай хамгийн их өвдөлттэй буюу маш их өвдөж байгаа хүнийг харуулж байна. Яг энэ мөчид чамд хир их өвдөлттэй байгааг чи надад энэ дундаас олж заа".

Тооцоолохдоо зүүнээс баруун тал руугаа чиглэж 0, 2, 4, 6, 8, 10 гэсэн байдлаар дүгнэлт өгнө. "0"= "огт өвдөлтгүй", харин "10"=" хамгийн их буюу маш их өвдөлттэй" гэснийг заана. Анхаарах нь : 1/ "огт өвдөлтгүй" ба "маш их өвдөлттэй" гэсэн хоёр заагийг маш тодорхой ялгаж илэрхийлэх хэрэгтэй. 2/ "гунигтай буюу уйтгартай" ба "аз жаргалтай буюу баяр баясгалантай" гэсэн 2 үгийг огт хэрэглэж хэлэхгүй байх. 3/ эдгээр хүмүүсийн царай нь хүүхдийн зөвхөн гадаад царайны төрхийг илэрхийлж байгаа гэдгийг онцлоно. Чиний бие чинь юу мэдэрч байгааг надад энэ зурган дээрээс /царайнууд дотроос/ олж заа.

Translation credit: Enkhzul Erdeneshoo & Nyamjargal Mangalsuren, Mongolia